

6 сарын цаг үеийн мэдээ

Төр захиргааны чиглэлээр:

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг зохион байгууллаа.

Хагас жилийн үйл ажиллагааны ХШҮ-ны тайланг 9 чиглэлээр ажлын хэсэг байгуулж зохион байгуулж байна.

Эрх зүйн баримт бичиг 16 ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 8, Аймгийн Засаг даргын албан даалгавар 1 ирж бусад салбарын тогтоол, тушаал 7 ирж хэрэгжиж байна.

Хагас жилийн өргөдөл, гомдлын мэдээг хүргүүллээ.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Онгон сумын нутаг шүлхий өвчний сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан сумын өвчлөмтгий мал сүргийг гоц халдварт шүлхий өвчний вакцинжуулалтанд хамруулсан. Үхэр сүргийг 100% хамруулсан. Үүнд: Үхэр-14973, Хонь-6756, Ямаа-3182 тус тус хамрагдсан. Үлдсэн хонь ямааг төлөвлөгөөт тарилга ирэхээр хамруулна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор туулгалт, боловсруулалтын ажил хийгдсэн.

Туулгалтанд: Адуу-1000, Үхэр-1500, Хонь-18000, Ямаа-9000, Нохой-350 тус тус хамрагдаж нийт-29850 хамрагдсан.

Боловсруулалтанд: Үхэр-6400, Адуу-2000, Хонь-9000, Ямаа-5000 тус тус хамрагдаж нийт-22400 хамрагдсан байна.

Ариутгал халдваргүйтгэлийг 99 объект, 41006м² талбайд хийлээ.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт үзлэг-150
- Урьдчилан сэргийлэх-150
- Артерийн гипертензин эрт илрүүлэг-5
- Чихрийн шижин эрт илрүүлэг-5
- Жирэмсний хяналтанд хамрагдсан-29
- Жинэлсэн хүүхдийн тоо-23
- Эмнэлэгт хэвтсэн-3
- Холын дуудлага-3
- Төвийн дуудлага-17
- ✓ 0-2 насны 26 хүүхдэд товлолын дархлаажуулалт хийсэн.

“Дэлхийн тамхитай тэмцэх” өдрийг хүрээнд 2 арга хэмжээ зохион байгууллаа.

“Ковид-19” өвчний эсрэг хариу арга хэмжээ:

- ✓ Сумын нийт өвчлөл- 132/14/ /эр-48, эм-51, хүүхэд- 33 /эр-17, эм-16/
- ✓ PCR шинжилгээнд- 443 иргэн /8/
- ✓ Түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан хүний тоо-730 /23/ Үүнээс:
 - эерэг-54
 - Сөрөг- 627
 - Сул эерэг-49
- ✓ Эдгэрсэн- 43 /19/ иргэн байна.

- ✓ Аймагт- 75, суманд- 1 иргэн эмчлэгдэж байна.
 - ✓ Гэрийн ажиглалтанд- 28 /өөр аймаг хотоос ирсэн/
 - ✓ ТАБ – 10 иргэн /буудал-10, ахмадын өргөө-0, соёлын төв-0/
 - ✓ ТЭБ- 1
 - ✓ Гэрийн тусгаарлалтанд- 267 /дам-72, ойр-195/
 - ✓ Давтан шинжилгээ- 1 баг, тандалт-1 баг ажиллаж байна.
 - ✓ Ариутгал: 1731м²
 - ✓ Вакцинжуулалт – 1121/782/70% /өөр сум, аймаг, хот-167 иргэн, эсрэг заалттай-55 иргэн байна./
- Хүүхэд /16-17 нас/- 30 /хийгдэж байна/
 “Нэг өрх-Нэг шинжилгээ” 429 өрх хамрагдахаас 429 өрх хамрагдсан 100%-тай.

Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

Төсвийн хуваарийн дагуу зарлагын гүйлгээг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж гүйлгээг баталгаажуулж ажиллалаа.

Төсөвт байгууллагуудын 5 сарын гүйцэтгэлийн мэдээг 6 сарын 2-нд хуулийн хугацаанд хянаж баталгаажуулсан. Өрийн мэдээг хүлээн авч программд шивж баталгаажуулсан.

Төрийн сангийн 5 сарын орлогыг эцсийн байдлаар 6 сарын 2-нд хааж дуусгасан.

Шилэн дансны сар бүрийн мэдээллийг 6 сарын 7-нд хуулийн хугацаанд мэдээлсэн.

Хагас жилийн малын түүвэр судалгааг явуулах Аймгийн засаг даргын 2021 оны А/345 дугаар захирамжийн дагуу сумын хэмжээнд 3 багийн 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон хагас жилийн түүвэр судалгаа 90%-тай явагдаж байна.

Газрын харилцаа:

Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах -1, эзэмших эрх бусдад шилжүүлэх -1, хэмжээ талбай өөрчлөх -2, өргөдөл хүлээн авч бүртгэж шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Өмчлөлын 1 нэгж талбарыг нөхөн бүрдүүлэн кадастрын мэдээллийн санд орууллаа. Мөн өргөдлийн дугаараар буруу холбогдсон 2 нэгж талбарын мэдээллийг засч оруулан мэдээллийг холбууллаа.

Газрын цахим бирж программд өдөр тутам нэвтэрч газрын татвар төлсөн аж ахуй нэгж иргэний нэхэмжлэхийг төлсөн төлөвт шилжүүлэн шалгах, ЛМ цахим программд өргөдөл бүртгэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Боловсролын чиглэлээр:

2020-2021 оны хичээлийн жилд нийт өдрийн ангиар 10 бүлэгт 261 суралцагч, дүйцсэн хөтөлбөрөөр 5 бүлэгт 18 суралцагч, 16 багш, 3 удирдлага, 17 ажилчидтай танхимын болон танхимын бус хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явагдлаа. Энэ хичээлийн жилд өдрөөр 219, дүйцсэн хөтөлбөрөөр 15 нийт 234 суралцагч анги дэвшиж, дүйцсэн хөтөлбөрөөр бага боловсролыг 3, өдрийн ангиар бага боловсролыг 26, суурь боловсролыг 16 суралцагч нийт 45 суралцагч амжилттай төгслөө.

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл эх үрсийн болон хүүхдийн эрхийн өдрийг угтан "Миний гэр бүлийн мөрөөдөл" гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Нийт 15 хүүхэд амжилттай оролцсон.

Байгаль орчны чиглэлээр:

210 ширхэг модонд 7 хоног бүрийн 3 дах өдөр усалгаа хийж байна. Шинээр тарьсан 350ш модны ргалтын хувь 90 хувьтай ургаж байна.

Байгаль хамгаалах өдрийн хүрээнд 3-р багийн нутагт орших Ширээ хавиргын булгийн хашааг сэргээн засварлаж, 2-р багийн нутагт орших Сөдөтийн голын хашаа элсэнд дарагдсан байсныг элснээс чөлөөлж сэргээн засварлалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Шинэ ажлын байр 6 иргэнийг iims праграммд бүртгээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төсөл дэмжигдсэн төсөл, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт дэмжигдсэн 2 иргэнтэй гэрээ хийж материалыг хүргүүлсэн байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдах өрхтэй холбогдож малыг 06 сард багтаан хүлэлцэхээр төлөвлөөд байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргаа сунгуулах 1 иргэний асуудлыг хэлэлцсэн.

Хүнсний эрхийн бичгийн 6 сарын олголтыг Ковид -19 цар тахлын өвчлөлтэй холбоотой 06 дугаар сарын 15,16,17-ны өдрүүдэд гэрээт дэлгүүрээр хүргэлтээр 13 өрхөд олголтыг хийгдсэн.

Насны хишиг,алдарт эхийн одонгийн мөнгө шинээр авах 7 иргэнтэй холбогдож Ехаламж цахим программд бүртгэл хийж мөнгийг олголоо.

Сард үйлчилгээ үзүүлж байгаа иргэдээ нас,хүйс,боловсрол,үйлчилгээ авсан төрлөөр нь дэлгэрэнгүй бүртгэл хөтлөн ажиллаж байна. Үүний дагуу 6 сарын 24-ны байдлаар 116 иргэнд 15 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Хөдөө аж, ахуй чиглэлээр:

Хүнсний ногооны тариалалт эхлэж байгаатай холбогдуулан үрийн төмс -400кг , төл сонгино- 10кг татан авч иргэдэд нийлүүлээд байна .

2 ААН-тэй гамшгийн үеийн хүнсний нөөцийг бүрдүүлэхээр хамтран ажиллахаар харилцан тохиролцож гэрээ байгууллаа.

ААН-үүдэд хяналт тавьж 52000/ мянган /төгрөгийн хугацаа хэтэрсэн хүнсний барааг хураан авч устгал хийгээд байна.

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байгаа 8 зээлдэгчид 2021.06.30-ны дотор зээлээ бүрэн төлөх талаар мэдэгдэл хүргүүллээ.